

ХИЛИЙН АЛБАНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ САЙЖРУУЛАХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES FOR IMPROVING THE BORDER OFFICE TRAINING PROGRAM

Г.Галбадрах

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Хилийн албаны удирдлага, стратегийн тэнхимийн дэд профессор, докторант, хурандаа

Galbadrakh.G

Associate professor, Department of Management and Strategy of Border Service, Academy of Management, University of Internal Affairs, Doctoral candidate, Colonel

Товч агуулга: Хилийн албаны бакалаврын сургалтын онцлог, өнөөгийн байдал, тулгамдаж байгаа асуудлыг төгсөгчдийг мөшгих судалгаа болон, гадаадын ижил төстэй цэргийн сургуулиудтай харьцуулан судалж, хөтөлбөрийг сайжруулах арга замыг эрэлхийлсэн санал дэвшүүлэхийг зорилоо.

Түлхүүр үгс: хил хамгаалах байгууллага, хилийн албаны офицер, цэргийн сургалт, чадамж олгох сургалт, хээрийн дадлага сургалт

Summary: The aim of this article is to figure out the features, current situation, challenging issues on bachelor study of Border protection in case of research result of graduated students and same military school's comparative study.

Keywords: border protection organization, border officer, military training, competency training, field training

Хилийн албаны мэргэжлийн бакалаврын сургалтын хөтөлбөрийн зорилго нь улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангаж, хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдах чадвар эзэмшүүлэх, үндэсний эх оронч үзэл, өргөсөн тангарагтаа үнэнч, албаны ёс зүй, цэргийн хэрэг, бие бялдар, сэтгэл зүйн өндөр төлөвшилтэй, мэдлэг, ур чадвараа тасралтгүй дээшлүүлэх чадвартай, хил хамгаалах байгууллагын хэрэгцээ

шаардлагыг хангасан хилчин офицер бэлтгэхэд оршиж байдаг.

“Хил судлал” бакалаврын сургалтын хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага нь Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, улсын хил хамгаалалтыг зохион байгуулж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын-Олон Улсын гэрээ хэлэлцээрийг хэрэгжүүлэх, түүнд нийцүүлэн гаргасан хилийн хууль тогтоомж, бусад эрх зүйн

баримт бичгүүд, хил хамгаалах байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг биелүүлэхтэй холбоотой хүний нөөцөд тавигдаж буй өнөөгийн шаардлагыг хангасан, чадавхид суурилсан мэдлэг, чадвар, хандлага төлөвшсөн офицерийг бэлтгэх асуудал юм.⁴

Хилийн албаны мэргэжил эзэмшсэн үе үеийн төгсөгчид хил хязгаараа эрхэмлэн дээдэлж, сахин хамгаалж ирсэн түүхэн уламжлалтай. Өнгөрөгч зууны 30-аад оны эхээр Монгол Улсын гадаад, дотоод цагийн байдал ихээхэн хурцадсаны улмаас төр, засгаас улс орноо батлан хамгаалахын тулд улсын хилийг мэргэжлийн цэргийн хүчээр хамгаалахаар шийдвэрлэн 1933 онд орчин цагийн Хил хамгаалах байгууллагыг, түүнчлэн Дотоод явдлын яамны сайдын 1934 оны 573 дугаар тушаалаар "Хил хязгаарыг хамгаалах шинэ хүчнийг бэлтгэн гаргах" 1 жилийн сургалттай түр курсыг байгуулснаар хилийн албаны мэргэжилтэн анхлан бэлтгэж эхэлсэн түүхтэй.

Одоо мөрдөж байгаа бакалаврын сургалтын хөтөлбөрийг их сургуулийн сургалтын бодлогын шинэчлэл, захиалагч тал Хил хамгаалах ерөнхий газартай хамтран төгсөгч, суралцагчдаас 2021 онд авсан судалгаанаас гарсан санал, дүгнэлтийн хүрээнд дахин шинэчлэн, сайжруулж 2023 оноос хэрэгжүүлж байна.


“Хилийн алба” бакалаврын сургалтын 2015 оны хөтөлбөр нь нийт 144 багц цагийн багтаамжтай⁵ байсан бол одоо хэрэгжиж байгаа “Хил судлал” бакалаврын сургалтын хөтөлбөрийн агуулга нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлүүдээс бүрдсэн нийт 120 багц цагийн багтаамжтай.

Танхимын болон танхимын бус сургалтын цагийг харьцуулж үзвэл лекц болон дасгал, лабораторын хичээлийн цаг нэмэгдсэн боловч семинар, хээрийн дадлага, бие даалтын хичээлийн цагууд багассан үзүүлэлттэй байна.

⁴“Хилийн алба-эрх зүй”D103802 бакалаврын сургалтын хөтөлбөр 2019 он.

⁵“Хилийн алба”D103802 бакалаврын сургалтын хөтөлбөр 2015 он.

“Хил судлал” хөтөлбөрийн багтаамж



Танхимын болон танхимын бус сургалтын харьцуулалт



Төгсөгчдийг мөшгих судалгаа /2021 он/

Төгсөгчдийг мөшгих судалгааг 2021 онд хилийн 31 ангийн дарга, удирдах бүрэлдэхүүнээс авч нэгтгэхэд:

Төгсөгчдийн мэдлэг, ур чадварт өгсөн үнэлгээ:

Маш сайн-11,
Сайн-272,
Дунд-453,
Муу-75,

Маш муу-3 буюу олонхи нь дунд түвшинд байна гэж үнэлсэн.

Төгсөгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд юуг анхаарах вэ? гэсэн нээлттэй асуулганд 24 хариултаас дараах 3 хариулт нийтлэг байна.

Бие бялдрын болон сэтгэл зүйн бэлтгэлжилтийг сайжруулах,

Албаны болон цэргийн хэргийн мэдлэг, чадварыг сайжруулах,

Онолоор үзсэн хичээлийг дадлага хийлгэж бататгах гэж хариулсан.⁶

Цэргийн сургалт нь танхимд суралцах онолын хичээл 40 орчим хувь, биеэр үйлдэж сурах /аливаа үйлдлийг олон дахин давтамжтай хийлгэж дадал чадвар суулгах/ хичээл 60 орчим хувьтай явагддаг онцлогтой. Жишээлбэл “Галын бэлтгэл” хичээлийн хүрээнд буудлагын зэвсэг, буудах арга барилын талаарх онолын мэдлэгийг тодорхой цагийн багтаамжаар хангалттай үзэж судалсан ч тухайн галт

зэвсгээр олон удаагийн давтамжаар илүү олон буудлага үйлдэж байж буудах арга барил, байг устгах чадвар олж авдаг.⁷

Хөтөлбөрийн агуулгыг гадаадын ижил төстэй цэргийн сургуулиудтай харьцуулж үзвэл мэргэжлийн суурь хичээл 37,5-43 хувь, мэргэжлийн хичээл 35,2-46,9 хувиар тус тус бага байна. Хэдийгээр ижил төстэй мэргэжил олгодог гадаадын цэргийн сургуулиудын суралцах хугацаа 5 жил боловч нийт хөтөлбөрийн багтаамж 161-180 багц цаг буюу “Хил судлал” хөтөлбөрөөс 25,6-33,3 хувиар их байна.

Хөтөлбөрийг гадаадын ижил төстэй сургуулиудтай харьцуулсан байдал⁸

Хөтөлбөр	Сурах хугацаа	Ерөнхий суурь хичээл	Мэргэжлийн суурь хичээл	Мэргэжлийн хичээл	Нийт кр/цаг
Хил судлал хөтөлбөр	4 жил	37кр/34%	29кр/26.8%	42кр/38.8%	120кр
ОХУ-ын Хабаровск хотын Хилийн академи	5 жил	45.2 кр/28%	50.9 кр/31.6%	64.9 кр/40.4%	161 кр
ОХУ-ын Калининград хотын Хилийн академи	5 жил	55.6 кр/33.6%	46.4 кр/28.1%	63 кр/38.3%	165 кр
Эстони Улсын ДЯЯ-ны Хилийн коллеж	3 жил	27 кр/22.5%	32 кр/26.6%	52 кр/50.9%	120 кр
БНХАУ-ын ХАЧА-ийн Хуурай замын цэргийн сургууль	5жил	54 кр/30%	46.8 кр/26% ⁹	79.2 кр/44%	180 кр

⁶Төгсөгчдийг мөшгих судалгаа /2021 он/ ХХЕГ

⁷Емец В.С., Сажин А.И. Личностно–ориентированное обучение: учеб.

пособие в понятиях, схемах, таблицах/. Пограничная академия, 2005.

⁸Тухайн цэргийн сургуулийг төгсөгчдийн дипломоос авав.

Дүгнэлт:

Цэргийн сургуулийн сургалтын үйл ажиллагаа нь чадамжид суурилсан, онолын мэдлэгийг хээрийн дадлагын хичээлээр бататгаж, цагийн байдлын ямарч нөхцөлд цэргийн хэргийн тактик үйл ажиллагааг биеэр хийж гүйцэтгэх чадвар бүхий алба хаагч-офицер бэлтгэхэд чиглэгдсэн байдаг.⁹

Мөн хилийн албаны хээрийн дадлага, сургалт нь танхимын сургалтаар үзэж судалсан онолын мэдлэгийг хилийн заставын бодит орчин нөхцөлд биеэр хийж гүйцэтгүүлэн бататгаж, хилийн аюулгүй байдлыг хангах, улсын хил хамгаалалт, хилийн заставын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хилийн манаа, харуулын албанд үүрэг гүйцэтгэх чадвар эзэмшүүлдэг онцлогтой, үр дүнтэй, сургалтын уламжлалт арга хэлбэр юм.¹⁰

Хээрийн дадлагын хичээлээр ердийн хил хамгаалалтын үед хилийн заставын хариуцсан хэсэгт улсын хил хамгаалалтыг зохион байгуулж удирдах, цагийн байдлыг судлах, үнэлэх, дүгнэх, түүнд тохирсон шийдвэр гаргах, хоногийн хил хамгаалах төлөвлөгөө боловсруулах, хил хамгаалах томилгооны хуваарь хийх, улсын хилийг хүч нэмэгдүүлэн хамгаалах болон хилийн эрлийн үед

хариуцсан хилийн заставын хэсэгт заставын даргын авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг сэдвийн хүрээнд сонсогчдод ур чадвар, дадал олгодог.

Гадаадын ижил төстэй мэргэжил олгодог цэргийн сургуулиудын хээрийн дадлага, сургалтын үргэлжлэх хугацаа 21-45 хоног байдаг бол “Хил судлал” хөтөлбөрийн хээрийн дадлагын сургалт 5-7 хоногийн хугацаанд үргэлжилж байна.

Иймд тус сургалтын хөтөлбөрийн агуулгад байгаа цэргийн хэрэг, хилийн албаны хичээлүүдийн багтаамж, хээрийн дадлага, сургалтын үргэлжлэх хугацааг хилийн цэргийн албаны онцлогт нийцүүлэн нэмэгдүүлэх шаадлагатай байна.

Санал:

“Хил судлал” бакалаврын сургалтын хөтөлбөрийг Хил хамгаалах байгууллагын захиалга, ажлын байрны эрэлт хэрэгцээ, шаардлагын дагуу Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах арга хэмжээ, Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого, Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах албаны үйл ажиллагааг гардан зохион байгуулах мэдлэг, чадвар, хандлага олгох зорилго, чиглэлд нийцүүлэн шинэчлэн боловсруулах;

⁹Давыдов В.П. Педагогика высшей школы Федеральной Пограничной службы Российской Федерации. Академия ФПС России, 2002.

¹⁰Вдовюк В.И., Шабанов Г.А. Педагогика высшей военной школы. Современные проблемы в структурно-логических схемах. М.: ВУ, 1996.

Бакалаврын сургалтын
хөтөлбөрийн 120 багц цагийн
багтаамжийг нэмэгдүүлж, дараах
чиглэлийн хичээлүүдийг нэмж
оруулах; Үүнд:

“Хил хамгаалалтын тактик”;

“Хилийн инженерийн
байгууламжийн хангалт”;

“Хилийн цэргийн ар талын
хангалт”;

“Цэргийн сэтгэл зүйн хангалт”

“Шалган нэвтрүүлэх алба”;

“Хилийн боомтын аюулгүй
байдал”;

“Галын бэлтгэл”;

“Ерөнхий цэргийн тактик”;

“Хил хамгаалалтын техник
хэрэгслийн ашиглалт”;

3. Хээрийн сургалт, дадлагад
төлөвлөгдсөн багц цагийг нэмэгдүүлэх;

Бакалаврын сургалтын
хөтөлбөрт дээрх өөрчлөлтүүд орсноор
хөтөлбөрийн зорилго, зорилт
хангагдаж, хил хамгаалах
байгууллагын хэрэгцээ, шаардлагад

нийцсэн хилчин-офицер бэлтгэх
боломж бүрдэнэ гэж үзэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Емец В.С., Сажин А.И.

Личностно–ориентированное
обучение: учеб. пособие в понятиях,
схемах, таблицах/. Пограничная
академия, 2005.

Давыдов В.П. Педагогика
высшей школы Федеральной
Пограничной службы Российской
Федерации. Академия ФПС России,
2002.

Вдовюк В.И., Шабанов Г.А.
Педагогика высшей военной школы.
Современные проблемы в структурно-
логических схемах. М.: ВУ, 1996.

ОХУ, БНХАУ-ын ижил төстэй
мэргэжил олгодог цэргийн сургуулийн
төгсөгчийн дипломууд.

Төгсөгчдийг мөшгих судалгаа
/2021 он/ ХХЕГ.